



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

202104.06 № 05/4054  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай


ХАРИЛЦАА ХОЛБОО,  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН  
ГАЗРЫН ДАРГА  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын харилцаа холбооны сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Феодорын Зоригоогийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Ф.Зоригоо нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-т “энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх”, 43.6-д “Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчихөөр байна.

Иймд тухайн албан тушаалд Төрийн албаны тухай хууль, салбарын хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцсэн этгээдийг нэр дэвшүүлж Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн томилох асуудлыг шийдвэрлэнэ үү.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА, АХЛАХ КОМИССАР



Л.СҮХ-ОЧИР